

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

9 сар  
2020

Баруун-Урт сумр



## ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл .....	3
Аргачлалын тайлбар .....	4-5
Товч танилцуулга .....	6-18
Үндсэн үзүүлэлтүүд .....	19

### I. Нийгмийн үзүүлэлт

I.2 Хөдөлмөр .....	20-22
I.2 Нийгмийн даатгал, нийгмийн халамж .....	23-24
I.3 Боловсрол .....	25-29
I.4 Эрүүл мэнд .....	30-31
I.5 Соёл, урлаг .....	32
I.6 Газар өмчлөл .....	33
I.7 Гэмт хэрэг .....	34-35

### II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Мөнгө, банк, даатгал .....	36
II.2. Төрийн санхүү .....	37-39
II.3 Төсөл хөтөлбөр .....	39
II.4 Үнэ .....	40-41
II.5 Хөдөө аж ахуй .....	42-47
II.6 Аж үйлдвэр .....	48-50



## Ерөнхий тэмдэглэл

### I. Товчилсон тэмдэглэлгээ:

Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

### II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI, VII, VIII, IX ...г.м)

Тухай сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IX зэргээр илэрхийлэв.

### III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

...	Мэдээлэл байхгүй	x	Бүтцийн өөрчлөлт
0.0	Маш бага тоо	+, -	Зөрүү
-	Гүйцэтгэл байхгүй	*	Дахин

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

### IV. 19-18 нь 2020 оны үзүүлэлтийн тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

### V. "Төл" нь төлөвлөгөөг, "Гүйц" нь гүйцэтгэл.

### VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Тэтгэвэр, тэтгэмж:** Уг мэдээг нийгмийн даатгал, халамж үйлчилгээний хэлтсүүд нь гарган нэгтгэж ирүүлдэг.
- **Эрүүл мэнд:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
  - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
  - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Соёл, урлаг:** Соёл, урлагийн үйл ажиллагааг эрхэлдэг газрууд нь мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.
- **Газар өмчлөл:** Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь сумдаас мэдээллийг авч нэгтгэн ирүүлсний дагуу мэдээллийг хүргэдэг.
- **Гэмт хэрэг:** Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
- 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.



- **Мөнгө, банк, даатгал:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг. Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд үндсэн үйл ажиллагааны мэдээллийг гаргаж ирүүлдэг.
- **Төсөл:** Засгийн газрын зарим гол төслүүд болон сангуудын хөрөнгийн зээл олголт, үйл ажиллагааны мэдээллийг холбогдох хэлтэс, агентлагууд гаргаж ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ гэдэг нь** өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.  
Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдол, тариалсан талбайн мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

**Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо:** гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

**Борлуулсан бүтээгдэхүүн нь** аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

**Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь** тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



## Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2020 оны эхний 9 сарын байдлаар)


### I. Нийгмийн үзүүлэлт



#### I.1. Хүн ам

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2020 оны эхний 9 сард 987 хүүхэд шинээр мэндэлж, 281 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 706 болж урьд оны мөн үеэс 18 (2.5%) хүнээр буурлаа. 1000 хүнд ногдох төрөлт 15.7, нас баралт 4.5 байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.3 пунктээр буурч, нас баралт 0.1 пунктээр өссөн байна.

Зураг.I.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 9 сард




#### I.2 Хөдөлмөр

Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2020 оны 9 дүгээр сарын эцэст 717 болсны 356 (49.6%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 508 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 236 (31.7%) хүнээр, 2019 оны 12 дугаар сарын эцсээс 122 (19.4%) хүнээр тус тус буурсан байна.

Эхний 9 дүгээр сарын байдлаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 1455 иргэн шинээр бүртгүүлсний 361 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Зураг.I.2.1 Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд





Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 259 (50.9%) 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 50.6% нь бүрэн дунд, 17.3% нь дээд, 14.4% нь суурь, 6.3% нь техник болон мэргэжлийн анхан шатны, 5.3% нь бага, 3.3% нь тусгай мэргэжлийн дунд, 2.8% нь боловсролгүй хүмүүс байна.

Зураг.1.2.2 Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр, 9 дүгээр сарын байдлаар



Эхний 9 дүгээр сарын байдлаар 269 шинэ ажлын байр бий болсны дотор уул уурхай олборлолтын салбар 103 (38.3%), барилгын салбар 72 (26.8%), боловсруулах аж үйлдвэрийн салбар 34 (12.6%), бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар 31 (11.5%) байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.



### 1.3 Эрүүл мэнд


Аймгийн хэмжээнд эхний 9 сарын байдлаар 194.7 мянган хүнд үзлэг хийсэн нь урьд оны мөн үеэс 10.3 (5.0%) мянган хүнээр буурч, 10.5 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 63.8 мянган хүн хамрагдсан нь урьд оны мөн үеэс 17.3 (30.7%) мянган хүнээр буурсан.

Түргэн тусламжийн дуудлага 13.3 мянган удаа гарсны 3.0 (22.5%) мянга нь алсын дуудлага байгаа нь урьд оны мөн үеэс 0.2 (6.2%) мянган удаагийн дуудлагаар буурсан байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 9 сард амаржсан эх 979, амьд төрсөн хүүхдийн тоо 987 болж, урьд оны мөн үеэс амаржсан эхийн тоо 14 (1.4%), хүүхдийн тоо 7 (0.7%)-оор тус тус буурсан байна.



Зураг.1.3.1 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо эхний 9 сард 394 болж, урьд оны мөн үеэс 226 (36.5%) өвчлөл буурсан бөгөөд гар, хөл амны өвчин 3 (13.6%), цусан суулга 35 (56.5%), салхинцэцэг 122 (65.6%), тэмбүү 95 (52.8%) тохиолдлоор буурсан нь голлон нөлөөлсөн байна.



### 1.3 Нийгмийн даатгал, халамж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 10.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 (19.4%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Нийт 9.0 мянган иргэнд 28.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосноос 6.8 мянган өндөр настанд 21.9 тэрбум төгрөг, 1.4 мянган тахир дутуу иргэнд 3.5 тэрбум төгрөг, 0.4 мянган тэжээгчээ алдсан иргэнд 1.1 тэрбум, 0.3 мянган иргэнд цэргийн тэтгэвэр 2.0 тэрбум төгрөг, үйлдвэрийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний тэтгэмжийг 26 иргэнд 0.1 тэрбум төгрөгийг тус тус бүрэн олгожээ. Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.5 хувиар өсчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр эхний 9 сард 25.9 мянган иргэнд 7.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, тусламж, дэмжлэгийг олгосон байна. Үүнийг төрлөөр нь авч үзвэл: Улсын төсвөөс нийгмийн халамжийн тэтгэвэрийг 1.3 мянган иргэнд 2.2 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 1.1 мянган иргэнд 0.8 тэрбум төгрөг, бусад хөнгөлөлт, тусламж, дэмжлэгт 14.6 мянган иргэнд 3.0 тэрбум төгрөгийг, орон нутгийн төсвөөс 1.3 мянган иргэнд 608.2 сая төгрөгийг тус тус олгожээ.



### 1.4 Боловсрол, шинжлэх ухаан

Ерөнхий боловсролын сургуульд 2020-2021 оны хичээлийн жилд 12.9 мянган суралцагчид байгаагийн 6.4 (50.1%) мянга нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс суралцагчдын тоо 569 (4.6%) хүүхдээр өсчээ.

Нийт суралцагчдын 6.9 (53.5%) мянга нь 1-5-р ангид, 4.1 (31.8%) мянга нь 6-9-р ангид, 1.9 (14.7%) мянга нь 10-12-р ангид суралцаж байна.




Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.5 мянган суралцагчид элсэн орсны 752 (50.5%) эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 75 (5.3%) суралцагчаар өссөн байна. Мөн 12-р ангид 0.7 мянган суралцагчид байгаагийн 399 (57.9%) нь эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 97 (16.3%) суралцагчаар өссөн байна.

Энэ хичээлийн жилд 439 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 29.3 суралцагч ногдож байна. 1 багшид ногдох суралцагчийн тоо 21 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1 (5.0%) хүүхдээр илүү түвшинд байна.

Нийт ажиллагсдын 624 (58.3%) үндсэн багш байна. Үүний 499 (80.0%) нь эмэгтэй багш нар байна. Өмнөх оны мөн үеэс багш нарын тоо 14 (2.3%) багшаар өссөн байна.

Дотуур байранд 947 сурагч амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 100 (9.6%) сурагчаар буурчээ.


Зураг I.4.1 Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо



**Сургуулийн өмнөх боловсрол** 2020-2021 оны хичээлийн жилд 176 бүлэгт 5.4 мянган хүүхэд хүмүүжиж байгаагийн 2.7 (50.0%) мянга нь эмэгтэй хүүхэд байна. Өмнөх оны мөн үеэс 189 (3.6%) хүүхдээр буурчээ.

Нийт хүмүүжиж байгаа хүүхдийн 4.4 (81.5%) мянга нь үндсэн цэцэрлэгт, 1.0 (18.5%) мянга нь хувилбарт сургалтанд хамрагджээ. Нийт ажиллагсдын 176 (48.5%) нь үндсэн багш байна.

Зураг I.4.2 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо






**Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв:** Сүхбаатар аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2020-2021 оны хичээлийн жилд 14 мэргэжлээр 440 суралцагчид суралцаж байгаагийн 170 (38.6%) нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс нийт суралцагчдын тоо 36 (8.9%) суралцагчаар өссөн байна.

Нийт суралцагчдын 110 (25%) мэргэжлийн боловсрол эзэмшихээр 1 жилийн хугацаатай суралцаж байгаа бөгөөд 330 (75%) мэргэжлийн боловсрол эзэмшихээр 2.5 жилийн хугацаатай суралцаж байна.

Нийт суралцагчдын 53 (12.0%) тогооч, 47 (10.7%) барилгын засал чимэглэгч, 45 (10.2%) гагнуурчин, 45 (10.2%) авто машины засварчин, 38 (8.6%) барилгын сантехникч, 36 (8.2%) гоо засалч, 35 (8.0%) бетон арматурчин гэх мэт мэргэжлээр сурч байгаа нь олонх байна.

Зураг I.4.3 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдын тоо




## I.6 Соёл, урлаг:

**Хөгжимт жүжгийн театр:** 1.3 мянган үзэгчдэд 5 тоглолтоор үйлчилж, 1.6 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс үзэгчдийн тоо 3.5 (72.9%), тоглолтын тоо 13 (72.2%), орлогын хэмжээ 3.6 (69.2%) сая төгрөгөөр тус тус буурсан.

Зураг I.6.1 Нийт тоглолтын тоо




Зураг I.6.2 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн






**Музей:** 2.1 мянган үзмэрээр 0.8 мянган хүнд үйлчилж, 1.0 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үзэгчдийн тоо 2.7 (77.1%) буурч, орлого 1.3 (56.5%) сая төгрөгөөр тус тус буурсан бөгөөд үзмэрийн тоо 3 (0.1%)-аар өсчээ.

Зураг I.6.3 Нийт үзмэрийн тоо




Зураг I.6.4 Нийт үзэгчдийн тоо




**Номын сан** Нийт 48.3 мянган номоор 2.4 мянган уншигчдад үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс номын тоо 1.4 (2.9%) өсч, уншигчдын тоо 3.0 (55.6%) мянган хүнээр буурчээ.

Зураг I.6.5 Нийт номын тоо



Зураг I.6.6 Нийт уншигчдын тоо, мян.хүн




## I.7 Газар өмчлөл:

**1.7.1** Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 11.3 мянган иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 10.4 мянган иргэнд 938.6 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байна.


Эхний 9 сард аж ахуйн зориулалтаар газар өмчлөхийг хүссэн 25 иргэний өргөдөл ирснийг 100 хувь шийдвэрлэжээ.



Зураг I.7.1 Газар өмчлөх өргөдөл гаргасан иргэдийн тоо



Зураг I.7.2 Засаг даргын шийдвэр гаргасан иргэдийн тоо



### I.8 Гэмт хэрэг

Энэ оны 3-р улирлын байдлаар нийт 300 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 9 хүн нас барж, 80 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 79 (20.8%) үйлдлээр буурчээ.


Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 1.2 тэрбум төгрөгийн хохирол учирсны 80.3 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 237 хүн холбогдон сэжиглэгдсэний 40.1 хувь нь согтуугаар, 21.1 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлджээ.

Нийт 417 хүн эрүүлжүүлэгдсэн нь урьд оны мөн үеэс 37 (9.7%) хүнээр өссөн байна. Нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсээс 162 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 48.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.3 пунктээр өссөн байна.

Зураг I.8 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо





## II. Эдийн засгийн үзүүлэлт




### II.1 Мөнгө, банк, даатгал

Монгол банкны мэдээгээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 136.5 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 8.7 (5.6%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 6.4 (4.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 83.6 тэрбум төгрөг болж оны эхнээс 7.7 (8.4%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 8.0 (10.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 9 дүгээр сарын эцэст 4.4 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.2 хувийг эзэлж байна

Зураг II.1.1 Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл сарын эцэст, тэрбум төг



**Даатгал:** Орон нутагт үйл ажилагаагаа явуулж буй даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 477.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн байна.

Нөхөн төлбөр 411 хүнд 69.4 сая төгрөг олгосны дотор авто тээврийн хэрэгсэлд 8.9 сая, жолоочийн хариуцлагад 28.0 сая, иргэдийн эд хөрөнгөнд 0.2 сая, гэнэтийн осолд 4.2 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 11.5 сая, хурдан морь унаач хүүхдийн даатгалд 1.4 сая, зуучлалын орлогод 15.2 сая төгрөгийг тус тус олгожээ.



## Зураг II.1.2 Даатгалын төрлөөр




## II.2 Төрийн санхүү:

Аймгийн төсвийн нийт орлого эхний 9 сард 50.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 11.1 (28.2%) тэрбум төгрөгөөр, төсвийн зарлага санхүүжилт 50.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 12.6 (33.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Орон нутгийн төсөвт 6.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0 (22.5%) тэрбум төгрөгөөр буурсан гүйцэтгэлтэй гарчээ.

Эхний 9 сарын байдлаар Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 9.1 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 2.5 (37.9%) тэрбум, улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг 23.9 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 4.0 (20.1%) тэрбум, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 5.6 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 2.6 (86.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зураг.II.2 Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг



## II.3 Төсөл хөтөлбөр:

Аймгийн хэмжээнд олгосон төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлаар авч үзвэл: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн



хэмжээнд 14 иргэнд 55.0 сая, нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөрийн хэмжээнд 207 иргэнд 48.7 сая, ахмад настны зөвлөх үйлчилгээнд 12 иргэнд 24.0 сая, хүнсний ногоо тариалах хөтөлбөрийн хүрээнд 66 иргэнд 16.6 сая, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 40 иргэнд 195.0 сая төгрөгийн төсөл санхүүжилтийг олгоод байна.




## II.4 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2020 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 1.4 хувь, жилийн эцсээс 0.7 хувиар тус тус өслөө.

Зураг II.3 Хэрэглээний үнийн индекс ( өмнөх оны 12 сар=100)



Хүснэгт II.3 Хэрэглээний үнийн индекс, 2020 оны 9 дүгээр сар, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2020.IX}{2019.IX}$	$\frac{2020.IX}{2019.XII}$	$\frac{2020.IX}{2020.VIII}$
<b>Ерөнхий индекс</b>	<b>101.4</b>	<b>100.7</b>	<b>99.6</b>
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	102.9	102.1	98.0
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	101.2	100.7	100.0
Хувцас, бөс бараа, гутал	103.7	102.6	100.6
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	102.2	102.0	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	102.2	101.4	100.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	103.9	103.3	101.3
Тээвэр	94.2	93.8	99.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.8	99.8	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	101.1	101.1	100.0
Боловсролын үйлчилгээ	100.5	100.5	100.5
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	115.8	109.6	100.0
Бусад бараа, үйлчилгээ	104.1	103.8	100.0



**Ерөнхий индекс өмнөх жилийн эцсээс 0.7 хувиар** өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 2.1 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисийн бүлгийн үнэ 0.7 хувь, хувцас бөс барааны бүлгийн үнэ 2.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 2.0 хувь, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 1.4 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ 3.3 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын барааны бүлгийн үнэ 1.1 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 0.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 9.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 3.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин тээврийн бүлгийн үнэ 6.2 хувь, холбооны хэрэглсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.2 хувиар тус тус буурчээ.




## II.5 Хөдөө аж ахуй

**Мал төллөлт, төл бойжилт.** Оны эхний төллөх насны хээлтэгч малын 82.7 хувь буюу 1.4 сая хээлтэгч эхний 9 сарын байдлаар төллөсөн байна. Таван төрлөөр нь авч үзвэл: эм хонь 84.3 хувь, эм ямаа 82.6 хувь, гүү 75.6 хувь, үнээ 77.3 хувь, ингэ 46.0 хувь тус тус төллөжээ.

Гарсан төлийн 98.5 хувь болох 1.4 сая төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.1 саяаар өссөн байна.

Төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл: Унага 98.9 хувь, тугал 99.1 хувь, хурга 98.7 хувь, ишиг 98.1 хувь, ботго 97.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс ботго 0.8 пунктээр буурч, бусад төрөлдөө 0.2-3.7 пунктээр өссөн байна.

Зураг-II.4.1 Төллөсөн хээлтэгчийн тоо, сумаар, мян.толгой, 2020 оны эхний 9 сарын байдлаар




Зураг-II.4.2 Бойжуулсан төлийн тоо, сумдаар, мян.толгой, 2020 оны эхний 9 сарын байдлаар





**Малын онд оролт:** Том малын зүй бус хорогдол эхний 9 сард 38.1 мянган толгой болж, өмнөх оны мөн үеэс 5.3 мянган толгойгоор буюу 12.2 хувиар буурсан байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 20, адуу 1.4 мянга, үхэр 2.6 мянга, хонь 18.5 мянга, ямаа 15.6 мянган толгой байна. Малын нийт хорогдлын 48.5 хувийг хонь эзэлж байна.


Зураг-II.4.3 Том малын зүй бусын хорогдол, мян.тол



Аймгийн хэмжээнд хорогдсон бүх мал нь оны эхний малын 1.0 хувийг эзэлж байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон мал 0.4 хувь буюу 136 толгой болж, өмнөх оны мөн үеэс 15.3 хувиар өсчээ.

**Ургац хураалт, хадлан бэлтгэл:** Ургац хураалтын явцын мэдээгээр аймгийн хэмжээнд эхний 9 дүгээр сард 1.7 мянган тн үр тариа, 561.7 тн төмс, 303.5 тн хүнсний ногоо, 645.0 тн техникийн ургамал, 1.9 тн тэжээлийн ургамал бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс үр тариа 2.7 дахин, техникийн ургамал 1.7 дахин, төмс 28.1 хувь, хүнсний ногоо 76.3 хувиар тус тус өсч, тэжээлийн ургамал 29.4 хувь, бэлтгэсэн өвс 13.8 хувиар тус тус буурчээ.

Зураг II.4.3 Хураасан ургац. тн-оор





## II.6 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 31.1 тэрбум төгрөг болж өмнөх оноос 4.9 (13.6%) тэрбум төгрөгөөр буурчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 0.2 (7.4%) тэрбум төгрөгөөр өсч, боловсруулах аж үйлдвэрийнх 1.4 (45.3%) тэрбум төгрөг, олборлох аж үйлдвэрийн салбарынх 3.6 (11.8%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Оны үнээр 125.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 89.7 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс хайлуур жонш, түгээсэн цэвэр ус, цахилгаан, зайрмаг, бууз, банш, бялуу, нарийн боов, цэвэр ус, хэвийн боов, платье, гал тогооны ерөөний модон тавилга, төрөл бүрийн модон эдлэл, хуванцар хүрээтэй хаалга, цонх, блок, сувагжуулалт зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс өссөн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН

ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ



## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар

	Хэмжих нэгж	2018	2019	2020	Зөрүү	$\frac{2020}{2019}$ %
<b>Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд</b>						
Төрсөн хүүхэд	хүн	984	994	987	- 7	99.3
Нялхасын эндэгдэл	хүн	11	9	9	-	100.0
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	771	744	508	- 236	68.3
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	529	620	394	- 226	63.5
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	260	379	300	- 79	79.2
Хэрэгт холбогсод	хүн	185	234	237	3	101.3
<b>Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт</b>						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар						
	хувь	104.6	104.6	100.7	- 3.9	96.3
Иргэдийн хадгаламж	сая.төг	64 970.0	75 631.4	101 823.7	26 192.3	134.6
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төг	135 510.7	142 907.3	136 543.2	-6 364.1	95.5
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	36 478.6	39 330.4	50 426.4	11 096.0	128.2
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	35 511.4	38 222.3	50 768.2	12 545.9	132.8
Төлөлсөн хээлтэгч	тол	1 295 415	1 385 055	1 425 824	40 769	102.9
-Ингэ	тол	1 252	1 282	1 448	166	112.9
-Гүү	тол	71 514	76 590	79 850	3 260	104.3
-Үнээ	тол	68 267	75 646	81 949	6 303	108.3
-Эм хонь	тол	712 162	770 828	785 696	14 868	101.9
-Эм ямаа	тол	442 220	460 709	476 881	16 172	103.5
Бойжуулсан төл	тол	1 258 048	1 324 540	1 408 820	84 280	106.4
-Ботго	тол	1 229	1 262	1 413	151	112.0
-Унага	тол	70 328	74 225	78 975	4 750	106.4
-Тугал	тол	67 306	74 821	81 241	6 420	108.6
-Хурга	тол	690 947	737 073	777 481	40 408	105.5
-Ишиг	тол	428 238	437 159	469 710	32 551	107.4
Том малын зүй бусын хорогдол	тол	73 229	43 440	38 128	-5 312	87.8
- Тэмээ	тол	28	22	20	- 2	90.9
- Адуу	тол	3 739	6 021	1 377	-4 644	22.9
- Үхэр	тол	6 839	1 229	2 645	1 416	215.2
- Хонь	тол	29 283	20 529	18 497	-2 032	90.1
- Ямаа	тол	33 340	15 639	15 589	- 50	99.7
Үүнээс: Өвчнөөр хоргдсон мал	тол	99	118	136	18	115.3
- Тэмээ	тол	-	-	-	-	-
- Адуу	тол	-	23	1	- 22	4.3
- Үхэр	тол	47	36	10	- 26	27.8
- Хонь	тол	45	59	60	1	101.7
- Ямаа	тол	7	-	65	-	-
Хураасан ургац, хадлан						
Үүнээс: Үр тариа	тн	748.0	632.9	1 730.0	1 097.1	273.3
Төмс	тн	442.3	438.5	561.7	123.2	128.1
Хүнсний ногоо	тн	214.8	172.2	303.5	131.3	176.2
Бэлтгэсэн өвс	тн	2 248.0	2 965.0	2 557.0	- 408.0	86.2
Гар тэжээл	тн	50.0	23.0	-	-	-
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	39 005.4	36 011.1	31 124.0	-4 887.1	86.4
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая.төг	214 436.0	215 158.7	125 411.2	-89 747.5	58.3



## I.1 ХӨДӨЛМӨР

### I.1.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2018		2019		2020	2020.IX 2019.IX %
	IX	XII	IX	XII	IX	
Асгат	27	24	8	15	3	37.5
Баяндэлгэр	42	37	42	36	27	64.3
Дарьганга	27	29	48	46	41	85.4
Мөнххаан	59	64	14	48	48	3.4*
Наран	22	23	30	40	28	93.3
Онгон	34	53	28	16	26	92.9
Сүхбаатар	75	92	70	65	67	95.7
Түвшинширээ	55	72	31	50	26	83.9
Түмэнцогт	33	23	53	29	21	39.6
Уулбаян	52	34	148	100	70	47.3
Халзан	39	13	30	12	3	10.0
Эрдэнэцагаан	78	17	70	35	37	52.9
Баруун-Урт	228	166	172	138	111	64.5
Дүн	771	647	744	630	508	68.3

### I.1.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд	Тусгай мэргэж-лийн дунд	Техник болон мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Асгат	3	3	-	1	1	-	1	-	-	-	-	3	-	-	-	-
Баяндэлгэр	27	14	-	8	2	1	9	5	1	1	2	12	7	6	-	-
Дарьганга	41	19	-	7	-	9	10	14	-	1	7	15	11	6	1	1
Мөнххаан	48	24	-	5	4	-	33	2	2	2	3	13	13	14	4	1
Наран	28	16	-	6	4	2	10	6	-	-	7	14	3	2	2	-
Онгон	26	13	-	4	-	-	19	2	1	-	1	10	11	3	1	-
Сүхбаатар	67	33	-	12	-	5	40	10	-	-	14	28	15	7	3	-
Түвшинширээ	26	11	-	5	1	2	5	6	7	-	4	11	8	3	-	-
Түмэнцогт	21	12	-	-	1	-	15	1	1	3	2	6	9	3	1	-
Уулбаян	70	34	-	7	1	3	28	15	9	7	10	22	23	9	5	1
Халзан	3	2	-	2	-	-	1	-	-	-	-	-	2	1	-	-
Эрдэнэцагаан	37	21	-	4	-	4	26	1	2	-	3	14	17	2	1	-
Баруун-Урт	111	43	-	27	3	6	60	11	4	-	21	37	36	15	2	-
Дүн	508	245	-	88	17	32	257	73	27	14	74	185	155	71	20	3



## I.1.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2018		2019		2020	2020.I-IX / 2019.I-IX %
	I-IX	I-XII	I-IX	I-XII	I-IX	
Асгат	124	175	77	92	14	18.2
Баяндэлгэр	72	117	78	132	120	153.8
Дарьганга	103	123	82	120	30	36.6
Мөнххаан	112	239	44	137	113	2.5*
Наран	146	153	114	157	101	88.6
Онгон	170	218	28	52	77	2.7*
Сүхбаатар	92	154	63	162	72	114.3
Түвшинширээ	153	241	119	177	144	121.0
Түмэнцогт	155	199	109	162	97	89.0
Уулбаян	51	58	222	312	143	64.4
Халзан	64	120	84	101	37	44.0
Эрдэнэцагаан	69	92	126	169	83	65.9
Баруун-Урт	1 071	1 341	767	990	424	55.3
Дүн	2 382	3 230	1 913	2 763	1 455	76.1

## I.1.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

Сум	2018		2019		2020	2020.I-IX / 2019.I-IX %
	I-IX	I-XII	I-IX	I-XII	I-IX	
Асгат	57	71	51	53	4	7.8
Баяндэлгэр	28	39	15	20	38	2.5*
Дарьганга	43	57	12	19	17	141.7
Мөнххаан	31	98	19	33	15	78.9
Наран	83	87	74	84	66	89.2
Онгон	66	70	5	5	10	200.0
Сүхбаатар	27	41	32	109	32	100.0
Түвшинширээ	71	113	73	90	49	67.1
Түмэнцогт	30	40	20	30	20	100.0
Уулбаян	2	8	32	64	48	150.0
Халзан	9	41	32	32	17	53.1
Эрдэнэцагаан	8	22	6	11	1	16.7
Баруун-Урт	189	251	207	252	44	21.3
Дүн	644	938	578	802	361	62.5



I.1.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо				Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар												
	2019. I-IX	2020. I-IX				Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах аж үйлдвэр	Бөөний болон жижиглэн худалдаа, машин моторликийн засвар	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Захирааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалах	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Урлаг, үзвэр, тоглоом наадам	Барилга	Бусад
		Бүгд	Үүнээс														
			Байнгын	Түр	Улирал												
Асгат	37	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баяндэлгэр	13	8	-	-	8	-	-	4	4	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	16	7	7	-	-	-	-	1	5	-	-	-	-	-	-	-	1
Мөнххаан	24	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Наран	28	4	-	3	1	1	-	-	-	-	-	3	-	-	-	-	-
Онгон	5	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	15	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Түвшинширээ	29	8	8	-	-	1	-	1	6	-	-	-	-	-	-	-	-
Түмэнцогт	23	3	3	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-	2	-
Уулбаян	23	1	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
Халзан	25	8	-	7	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	8
Эрдэнэцагаан	11	1	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Баруун-Урт	206	229	229	-	-	-	103	27	16	5	5	1	-	-	-	72	-
Дүн	455	269	249	10	10	2	103	34	31	5	5	5	-	-	1	72	11

**I.2 НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ****I.2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ, сумаар, сая.төг**

Сум	Нийгмийн даатгалын шимтгэл				Үүнээс: сайн дурын даатгал			
	2019.I-IX	2020.I-IX			2019.I-IX	Шимтгэлийн орлого		
		Төл	Гүйц	%		Төл	Гүйц	%
Асгат	227.8	161.2	188.7	117.0	49.0	59.1	55.5	93.8
Баяндэлгэр	529.3	340.3	412.0	121.1	94.4	118.1	148.3	125.6
Дарьганга	357.3	232.9	269.5	115.7	66.0	88.0	108.9	123.8
Мөнххаан	468.4	316.5	339.4	107.2	89.6	115.3	149.8	130.0
Наран	233.8	139.8	170.3	121.9	51.5	63.0	72.9	115.8
Онгон	630.2	443.8	521.6	117.5	67.1	84.9	98.8	116.3
Сүхбаатар	358.4	247.7	274.7	110.9	52.0	69.6	97.4	140.0
Түвшинширээ	320.8	213.9	265.7	124.2	47.1	60.6	82.0	135.2
Түмэнцогт	531.8	382.0	472.9	123.8	46.4	58.5	76.7	131.1
Уулбаян	428.4	331.9	339.6	102.3	52.0	65.5	94.9	144.8
Халзан	221.2	159.1	193.9	121.9	25.2	32.7	36.7	112.1
Эрдэнэцагаан	892.1	616.3	738.3	119.8	139.5	175.3	247.5	141.2
Баруун-Урт	8 173.6	6 215.8	7 788.3	125.3	294.3	552.5	553.6	100.2
Дүн	13 373.1	9 801.3	11 974.9	122.2	1 074.1	1 543.2	1 823.0	118.1

**I.2.2 ТЭТГЭВЭР ОЛГОЛТ, сумаар**

Сум	Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо				Олгосон тэтгэвэр сая.төг			
	2018.I-IX	2019.I-IX	2020.I-IX	$\frac{2020.I-IX}{2019.I-IX}$ %	2018.I-IX	2019.I-IX	2020.I-IX	$\frac{2020.I-IX}{2019.I-IX}$ %
Асгат	257	262	312	119.1	492.4	742.5	916.8	123.5
Баяндэлгэр	635	620	706	113.9	1 192.8	1 788.2	2 176.9	121.7
Дарьганга	357	363	445	122.6	671.2	1 026.2	1 297.3	126.4
Мөнххаан	530	518	586	113.1	982.1	1 460.0	1 748.3	119.7
Наран	213	190	244	128.4	402.6	614.2	751.7	122.4
Онгон	508	504	544	107.9	1 073.9	1 586.4	1 829.7	115.3
Сүхбаатар	392	385	427	110.9	713.7	1 056.5	1 267.8	120.0
Түвшинширээ	389	386	437	113.2	721.9	1 046.0	1 267.0	121.1
Түмэнцогт	364	361	401	111.1	713.9	1 011.7	1 231.0	121.7
Уулбаян	408	391	455	116.4	742.3	1 106.6	1 339.9	121.1
Халзан	203	201	235	116.9	381.4	556.4	694.4	124.8
Эрдэнэцагаан	793	768	870	113.3	1 614.5	6 805.9	2 828.4	41.6
Баруун-Урт	3 073	3 056	3 386	110.8	7 397.2	9 540.9	11 225.6	117.7
Дүн	8 122	8 005	9 048	112.5	17 099.9	28 341.5	28 574.6	100.8



## I.2.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг

Үзүүлэлт		2019.I-IX		2020.I-IX		
		Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	
Улсын төсөвөөс	<b>1 Халамжийн тэтгэвэр</b>	<b>1 320</b>	<b>1 817.8</b>	<b>1 321</b>	<b>2 246.5</b>	
	<b>2 Халамжийн тэтгэмж</b>	<b>1 991</b>	<b>1 007.8</b>	<b>2 216</b>	<b>1 377.8</b>	
	<b>1. Асаргааны тэтгэмж</b>	<b>1 057</b>	<b>626.9</b>	<b>1 149</b>	<b>810.9</b>	
	байнгын асаргаа шаардлагатай	Ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	571	322.1	651	411.4
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	239	138.3	243	156.6
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	202	135.2	208	207.7
	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	16	10.0	17	10.8	
	Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	10	9.7	10	9.8	
	Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	19	11.6	20	14.6	
	<b>3 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал</b>	<b>7 181</b>	<b>722.3</b>	<b>6 283</b>	<b>1 069.3</b>	
	<b>4 Ахмад настны нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт</b>	<b>4 279</b>	<b>284.3</b>	<b>2 284</b>	<b>272.6</b>	
	<b>5 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж</b>	<b>16</b>	<b>21.2</b>	<b>15</b>	<b>21.0</b>	
	<b>6 ХБ-тэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж</b>	<b>403</b>	<b>88.3</b>	<b>440</b>	<b>102.2</b>	
	<b>7 Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж</b>	<b>5 631</b>	<b>451.8</b>	<b>5 537</b>	<b>1 557.2</b>	
	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	3 942	137.8	3 885	1 234.1	
Жирэмсэн эхийн тэтгэмж	1569	205.8	1 512	186.8		
Ихэр хүүхдийн тэтгэмж	7	14.0	19	38.0		
3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд 1 удаа	113	94.7	121	98.3		
<b>8 Насны хишиг</b>	<b>2 517</b>	<b>394.4</b>	<b>2 657</b>	<b>415.7</b>		
<b>9 Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж</b>	<b>5 104</b>	<b>695.7</b>	<b>5 133</b>	<b>679.9</b>		
Халамжийн сангаас	<b>1 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>934</b>	<b>380.9</b>	<b>1067</b>	<b>566.9</b>	
	Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн	722	102.2	835	128.0	
	16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	193	255.9	210	412.5	
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	3	3.6	3	3.6	
	Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа олгох тэтгэмж	11	13.2	16	19.2	
	Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	5	6.0	3	3.6	
	<b>2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ</b>	<b>36</b>	<b>21.9</b>	<b>230</b>	<b>41.3</b>	
<b>ДҮН</b>		<b>28 442</b>	<b>5 483.6</b>	<b>25 886</b>	<b>7 742.2</b>	

**I.3 БОЛОВСРОЛ****I.3.1. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАГЦАГЧДЫН ТОО /сумдаар/**

Сум	Сургуулийн ангилал	Нийт дүн					1-5-р анги			6-9-р анги		10-12-р анги			Үндсэн багшийн тоо	1 багшид ногдох сурагчийн тоо	Дотуур байранд амьдардаг сурагч
		Бүлэг	Бүх сурагчид	Үүнээс: эмэгтэй	Эмэгтэй хүүхдийн эзлэх хувь	Нэг бүлэгт ногдох сурагч	Бүх суралцагчид	Бүгдээс: эмэгтэй	Үүнээс: 1-р ангид	Бүх суралцагчид	Бүгдээс: эмэгтэй	Бүх суралцагчид	Бүгдээс: эмэгтэй	Үүнээс: 12-р ангид			
Ас	дунд	11	271	124	45.8	24.6	154	70	41	117	54	-	-	-	14	19	41
Бд	ахлах	35	1 078	539	50.0	30.8	548	263	122	345	170	185	106	82	52	21	120
Да	дунд	21	531	263	49.5	25.3	295	155	72	177	75	59	33	-	29	18	36
Мх	ахлах	35	970	499	51.4	27.7	525	264	98	309	154	136	81	47	50	19	84
На	дунд	10	260	143	55.0	26.0	169	97	44	91	46	-	-	-	15	17	33
Он	ахлах	28	736	355	48.2	26.3	404	180	86	199	99	133	76	46	38	19	38
Сб	дунд	19	455	211	46.4	23.9	290	138	62	165	73	-	-	-	25	18	62
Тш	дунд	22	608	295	48.5	27.6	345	164	77	207	97	56	34	-	30	20	82
Тц	ахлах	22	538	283	52.6	24.5	282	144	64	164	85	92	54	34	33	16	45
Уб	дунд	17	442	212	48.0	26.0	276	127	50	166	85	-	-	-	21	21	48
Ха	дунд	10	205	110	53.7	20.5	145	81	28	60	28	-	-	-	14	15	40
Эц	ахлах	44	1 377	699	50.8	31.3	719	360	156	459	238	199	101	66	56	25	100
I БДС	ахлах	58	2 030	1 019	50.2	35.0	1 033	515	240	568	267	429	237	161	86	24	75
II БДС	ахлах	39	1 149	570	49.6	29.5	617	282	112	365	187	167	101	70	58	20	39
III БДС	ахлах	27	859	437	50.9	31.8	419	198	71	268	143	172	96	69	41	21	26
IV БДС	ахлах	41	1 357	690	50.8	33.1	708	343	166	415	211	234	136	118	62	22	78
Дүн		439	12 866	6 449	50.1	29.3	6 929	3 381	1 489	4 075	2 012	1 862	1 055	693	624	21	947
2019		424	12 297	6 130	49.8	29.0	6 665	3 226	1 414	3 717	1 818	1 915	1 086	596	610	20	1 047
2018		402	11 563	5 769	49.9	28.8	6 378	3 118	1 371	3 565	1 733	1 620	918	306	576	20	952
2017		395	11 284	5 662	50.2	28.6	6 034	2 964	1 484	3 599	1 753	1 651	945	713	567	20	959
2016		370	10 764	5 395	50.1	29.0	5 474	2 675	1 233	3 568	1 734	1 722	986	690	549	20	970
2015		371	10 471	5 248	50.1	28.0	5 142	2 487	1 266	3 221	1 574	2 108	1 187	676	535	20	980
2014		366	10 034	4 995	49.8	27.0	4 753	2 291	1 067	3 369	1 660	1 912	1 044	520	523	19	921
2013		355	9 801	4 855	49.5	28.0	4 729	2 267	1 022	3 392	1 672	1 680	916	456	514	19	924



## I.3.2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 1, 12-Р АНГИД СУРАЛЦАГЧИД

Сум	1-р ангид				12-р ангид			
	2019-2020		2020-2021		2019-2020		2020-2021	
	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
Ас	28	14	41	17	-	-	-	-
Бд	109	62	122	59	57	35	82	46
Да	45	17	72	46	-	-	-	-
Мх	105	44	98	49	46	28	47	28
На	27	14	44	24	-	-	-	-
Он	72	31	86	42	40	17	46	24
Сб	59	29	62	31	-	-	-	-
Тш	77	37	77	37	-	-	-	-
Тц	56	30	64	35	40	22	34	20
Уб	60	27	50	29	-	-	-	-
Ха	38	19	28	16	-	-	-	-
Эц	147	65	156	77	75	51	66	35
I БДС	226	106	240	128	123	70	161	101
II БДС	127	54	112	46	72	39	70	42
III БДС	100	40	71	35	54	25	69	37
IV БДС	138	75	166	81	89	59	118	66
дүн	1 414	664	1 489	752	596	346	693	399

## I.3.3. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД АЖИЛЛАГСДЫН ТОО, сумдаар

Сургуулиуд	Нийт ажиллагсад			Үндсэн багш			Сургалтын менежер			Нийт ажиллагсдын дотор үндсэн багшийн эзлэх хувь	
	2019	2020-2021		2019	2020-2021		2019	2020-2021		2019-2020	2020-2021
		Бүгд	эм		Бүгд	эм		Бүгд	эм		
Ас	34	36	26	14	14	12	1	1	1	41.2	38.9
Бд	93	94	73	52	52	44	3	3	1	55.9	55.3
Да	49	52	39	27	29	23	2	2	2	55.1	55.8
Мх	88	89	64	50	50	41	3	3	3	56.8	56.2
На	33	35	20	14	15	9	1	1	1	42.4	42.9
Он	65	66	50	38	38	32	2	2	1	58.5	57.6
Сү	44	46	37	24	25	20	1	1	-	54.5	54.3
Тш	61	60	45	29	30	24	2	2	2	47.5	50.0
Тц	54	56	41	32	33	24	2	2	2	59.3	58.9
Уб	47	45	33	23	21	19	1	1	1	48.9	46.7
Ха	32	32	26	13	14	10	1	1	1	40.6	43.8
Эц	91	91	74	57	56	45	3	2	2	62.6	61.5
I БДС	125	126	93	84	86	66	4	4	3	67.2	68.3
II БДС	85	86	65	57	58	48	3	3	1	67.1	67.4
III БДС	63	65	51	38	41	33	2	3	3	60.3	63.1
IV БДС	88	91	71	58	62	49	3	2	2	65.9	68.1
дүн	1 052	1 070	808	610	624	499	34	33	26	58.0	58.3



## I.3.4. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН МЭДЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сумдын цэцэрлэг	Бүлгийн тоо		Байрны хүчин		2019-2020			2020-2021		
	2019-2020	2020-2021	2019-2020	2020-2021	Хамрагдвал зохиx	Хамрагдсан		Хамрагдвал зохиx	Хамрагдсан	
						Бүx хүүхэд	Үүнээс: эмэгтэй		Бүx хүүхэд	Үүнээс: эмэгтэй
Асгат	6	6	100	100	180	160	83	177	163	81
Баяндэлгэр	13	12	175	175	459	425	223	448	392	203
Дарьганга	7	7	100	100	265	230	123	243	200	94
Мөнххаан	11	11	200	200	426	355	190	435	342	165
Наран	5	5	75	75	167	155	77	146	142	72
Онгон	9	9	250	175	343	325	144	337	302	140
Сүхбаатар	9	8	125	125	327	308	143	343	330	144
Түвшинширээ	10	10	110	200	367	360	171	366	359	166
Түмэнцогт	8	8	100	100	218	220	107	202	197	93
Уулбаян	7	7	100	100	243	210	101	257	211	108
Халзан	4	5	75	100	153	130	68	161	122	58
Эрдэнэцагаан-1	9	9	125	125	620	307	155	600	253	129
Эрдэнэцагаан-2	8	8	100	100	-	250	130	-	232	118
1-р цэцэрлэг	4	8	100	100	2 331	136	72	2 370	246	130
2-р цэцэрлэг	7	8		175		262	128		240	116
3-р цэцэрлэг	7	8	150	150		235	122		249	130
4-р цэцэрлэг	6	6	100	100		193	88		185	86
5-р цэцэрлэг	5	4	75	75		160	86		136	71
6-р цэцэрлэг	4	5	100	100		134	66		144	73
7-р цэцэрлэг	4	4	75	75		127	66		129	70
8-р цэцэрлэг	8	8	150	150		274	137		273	137
9-р цэцэрлэг	8	8	175	175		283	134		221	104
10-р цэцэрлэг	6	6	125	125		193	99		166	82
11-р цэцэрлэг	6	6	151	150		176	101		185	104
Дүн	171	176	2 836	3 050	6 099	5 608	2 814	6 085	5 419	2 674



## I.3.5. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН АЖИЛЛАГСДЫН ТОО

Цэцэрлэг	Нийт ажиллагсад			Үндсэн багш			Туслах багш			Нийт ажиллагсдын дотор үндсэн багшийн эзлэх хувь	
	2019-2020	2020-2021		2019-2020	2020-2021		2019-2020	2020-2021		2019-2020	2020-2021
		Бүгд	эм		Бүгд	эм		Бүгд	эм		
Асгат	18	18	15	4	5	5	4	4	4	22.2	27.8
Баяндэлгэр	32	32	26	10	10	9	9	9	9	31.3	31.3
Дарьганга	26	25	20	7	7	7	6	6	5	26.9	28.0
Мөнххаан	39	38	30	13	13	12	11	11	8	33.3	34.2
Наран	16	16	13	4	4	4	4	4	4	25.0	25.0
Онгон	29	29	25	9	9	9	8	8	8	31.0	31.0
Сүхбаатар	26	26	21	7	8	7	7	7	7	26.9	30.8
Түвшинширээ	32	32	27	10	9	9	8	8	8	31.3	28.1
Түмэнцогт	27	26	22	8	8	8	8	8	8	29.6	30.8
Уулбаян	23	22	18	7	7	7	5	5	5	30.4	31.8
Халзан	16	16	14	5	5	5	4	4	4	31.3	31.3
Эрдэнэцагаан-1	31	29	25	9	8	8	8	8	8	29.0	27.6
Эрдэнэцагаан-2	21	20	17	5	5	5	5	5	5	23.8	25.0
1-р цэцэрлэг	20	33	31	5	9	9	4	8	8	25.0	27.3
2-р цэцэрлэг	25	29	22	8	9	7	4	7	7	32.0	31.0
3-р цэцэрлэг	27	28	21	8	9	8	6	7	7	29.6	32.1
4-р цэцэрлэг	22	22	17	6	6	5	5	5	5	27.3	27.3
5-р цэцэрлэг	18	19	16	5	5	5	3	4	4	27.8	26.3
6-р цэцэрлэг	18	20	16	5	5	5	2	4	4	27.8	25.0
7-р цэцэрлэг	20	20	15	5	5	5	4	4	4	25.0	25.0
8-р цэцэрлэг	31	32	26	8	9	9	6	7	7	25.8	28.1
9-р цэцэрлэг	31	31	27	9	9	9	7	7	7	29.0	29.0
10-р цэцэрлэг	22	21	15	6	6	5	5	5	5	27.3	28.6
11-р цэцэрлэг	22	25	20	4	6	5	4	6	5	18.2	24.0
Дүн	592	609	499	167	176	167	137	151	146	28.2	28.9

**I.3.6 ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, ЭЗЭМШИХЭЭР СУРЧ БАЙГАА СУРАЛЦАГЧИД**

Үзүүлэлт	Суралцагчид			Мэргэжлийн боловсрол					Мэргэжлийн сургалт		
	2019	2020	Үүнээс эмэгтэй	2019	2020	Үүнээс эмэгтэй	I курс	Үүнээс эмэгтэй	2019	2020	Үүнээс эмэгтэй
Тогооч	67	53	47	53	53	47	-	-	14	-	-
Авто машины засварчин	25	45	-	25	45	-	30	-	-	-	-
Гагнуурчин	41	45	4	41	45	4	30	4	-	-	-
